

**ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ, ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ЕРӨНХИЙ ГАЗАР  
МОНГОЛЫН АЖИЛ ОЛГОГЧ ЭЗДИЙН НЭГДСЭН ХОЛБООНЫ  
ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ**

2014 оны 09 дүгээр  
сарын 25-ны өдөр

Улаанбаатар  
хот

Нэг талаас Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар /Ерөнхий газар"/ негеэ талаас Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо /"Холбоо"/ /цаашид "Талууд" гэх/ хамтран ажиллах талаар дор дурдсан зүйлийг харилцан тохиролцож, энэхүү "Санамж бичиг"-ийг үйлдэв.

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Талуудын хамтын ажиллагааны зорилго нь бизнес эрхлэгч, гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллага, ажил олгогч эздэд Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу үйл ажиллагаа явуулахад шаардагдах үнэн зөв мэдээ мэдээллийг хүргэх, бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааны үр ашгийг нийгэм, эдийн засгийн хүрээнд сурталчлан таниулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

1.2. Талууд бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэхтэй холбогдсон асуудлаар харилцан мэдээлэл солилцох, үндэсний болон орон нутгийн хэмжээнд уулзалт, сургалт зөвлөлгөөнийг зохион байгуулж болох бөгөөд тухай бүр санал солилцено.

1.3. Талуудын үйл ажиллагаа нь хуульд нийцсэн, ил тод, нээлттэй, үр дүнтэй байх, харилцан зөвшилцөх зарчимд тулгуурлана.

1.4. Хамтын ажиллагаанд аль нэг талын болон бусад этгээдийг төлөөлсөн, давамгайлсан ашиг сонирхол, хүсэл зорилгыг илэрхийлсэн байр суурьнаас хандахгүй бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжийг удирдлага болгоно.

1.5. Талууд энэхүү "Санамж бичиг"-ийн хүрээнд хийсэн үйл ажиллагааны биелэлтийг хагас, бүтэн жилээр тогтмол дүгнэж байна.

### **ХОЁР. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ**

2.1. Хууль тогтоомж болон холбогдох дурэм, журмыг сурталчлан таниулах чиглэлээр:

2.1.1. талууд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон түүнтэй нийцуулэн гаргасан бусад хууль эрх зүйн актыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллага, ажил олгогч эзэд болон олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах;

2.1.2. холбогдох хууль эрх зүйн орчинг уялдуулан шинэчлэх, боловсронгий болгох асуудлаар санал солилцох;

2.1.3. Ерөнхий газрын үйл ажиллагааны болон холбогдох хууль тогтоомжийн талаар ажил олгогч эздэд зориулсан гарын авлага гаргах;

2.1.4. талууд нь нийгэмд үр ашигтай байхаар чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэхэд холбогдох хууль тогтоомжийн дагуу харилцан дэмжлэг үзүүлэх;

2.1.5. Холбоо нь өөрийн гишүүн ажил олгогч эздэд хандан гаргах бодлогын баримт бичиг, түүнд холбоотой аливаа зөвлөмж, шийдвэрийг гаргахдаа Ерөнхий газрын саналыг авч болно.

## 2.2. Сургалт, судалгаа, мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр:

2.2.1. бизнесийн салбарт холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар судалгаа хийх, дүгнэх, шаардлагатай мэдээ, мэдээллийг бизнес эрхлэгчдэд хүргэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2.2.2. гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллагад холбогдох хууль тогтоомжийн талаар зөвлөмж, мэдээллийг өгөх бөгөөд шаардлагатай тохиолдолд Ерөнхий газрын зөвшөөрснөөр Холбоо олон нийттэй харилцах хэрэгсэл /зурагт, радио, сонин, хэвлэл, интернэт г.м/-тэй хамтран ажиллаж болно;

2.2.3. Холбоо нь өөрийн гишүүн байгууллагуудад Ерөнхий газраас хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар сургалт, семинар, уулзалт, зөвлөлгөөнд Ерөнхий газрын төлөөлөгчийг оролцуулах хүсэлт тавьж оролцуулж болно;

2.2.4. талууд хамтын ажиллагааны хүрээнд мэдээллийн сан бий болгож нэгтгэн, цахим хэлбэрээр албан ёсны вэб сайтад байршуулан, мэдээллийг тогтмол шинэчлэх ажлыг хэрэгжүүлэх ба буруу эсхүл сөрөг мэдээлэл түгээхийг хориглоно;

2.2.5. гадаадаас ажиллах хүч авч ажиллуулдаг болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллагуудад зориулсан мэдээ, мэдээллийн хүртээмж, чанарыг сайжруулах ажлыг эрчимжүүлнэ;

2.3. Хамтран зохион байгуулах ажлын хүрээнд талууд зөвшилцөн гаргасан төлөвлөгөөт хугацаанд багтаж ажлыг хийж гүйцэтгэнэ.

2.4. Хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнд ямар нэгэн эрх ашиг хохирсон нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу буруутай этгээдэд хариуцлага тооцно.

## ГУРАВ. САНАМЖ БИЧГИЙН ХУГАЦАА

3.1. Энэхүү "Санамж бичиг"-ийг 1 /нэг/ жилийн хугацаатай байгуулах бөгөөд хугацаа дуусахаас өмнө аль нэг талын санаачлагаар түүнийг цуцалж болно. Энэ тохиолдолд цуцлах хүсэлтэй тал нь шийдвэрээ 30 хоногийн өмнө негөө талд бичгээр мэдэгдэнэ.

3.2. Санамж бичгийн хугацаа дуусахад аль нэг тал нь санамж бичгийг цуцлах талаар санал тавиагүй бол санамж бичгийг анх байгуулсан хугацаагаар дахин сунгагдсанд тооцно.

## ДӨРӨВ. БУСАД ЗҮЙЛ

4.1. Энэхүү Санамж бичгийг 2 хувь үйлдэх бөгөөд Талууд нэг нэг хувийг өөрт хадгална.

4.2. Санамж бичиг нь түүнд талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

4.3. Санамж бичигт Талууд харилцан тохиролцсоноор нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ,  
ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА

Б.ПҮРЭВДОРЖ



МОНГОЛЫН АЖИЛ ОЛГОГЧ  
ЭЗДИЙН НЭГДСЭН ХОЛБООНЫ  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

